



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянгол, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Сант, Есөнзүйл сумдад оторлож буй малчдад нүүрсний дэмжлэг үзүүлэх, шуудайлах, тээвэрлэх зардлын тооцоог хавсралтаар баталсугай

2.Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилт хүндрэх онцгой эрсдэл үүсэж, өвлийг хохирол багатай даван туулах зорилгоор сумдын өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3.Хавсралтад тусгагдсан 9,255,000 (есөн сая хоёр зуун тавин таван мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0003

Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дугаар захирамжийн хавсралт



НҮҮРС ТЭЭВЭРЛЭХ, ШУУДАЙЛАХ БОЛОН ОТРЫН
МАЛЧДАД ХҮРГЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (мянган төгрөг)	Нийт үнэ (мянган төгрөг)
1	Нүүрс тээвэрлэх унааны зардал	30.0 тонн	100,000	3,000,000
2	Шуудай	750 шуудай	0,8	600,000
3	Төмөр утас (шуудайны ам боох)	5 кг	6.0	30,000
4	Нүүрс буулгах, шуудайлах, ачих зардал (Цэргийн анги)	750 шуудай	1,5	1,125,000
5	Малчдад шуудайлсан нүүрс хүргэх зардал (3 хэсэгт нүүрс хүргэх)	150 өрх	4,5	4,500,000
				9,255,000